МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 07 өдөр Дугаар А/687 Алтай хот

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7 дахь заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын "Улаан шороо" нэртэй 334.18 гектар талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатайгаар "Климакс референс" ХХК-д олгосугай.

2.Хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, хуулиар хүлээсэн нийтлэг үүргийг биелүүлж, ажиллахыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Климакс референс" ХХК (Б.Мөнхтөр)-д үүрэг болгосугай.

3.Хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрөл, зурагзүйн бүртгэлд бүртгэж, хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтанзагас), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

020199234